



БАТЛАВ.



№337

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Улаанбаатар хот

2022.10.26

Нэг талаас: Зам, тээврийн хөгжлийн яам /цаашид “Захиалагч тал” гэх/, түүнийг төлөөлж Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ц.Одхүү, нөгөө талаас: “Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар” ТӨААТҮГ /цаашид “Гүйцэтгэгч тал” гэх/, түүнийг төлөөлж захирал Ө.Лувсанренчин нар харилцан тохиролцож Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хуулийн холбогдох зүйл, заалтуудыг үндэслэн дараах нөхцөлтэйгээр энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү гэрээгээр гүйцэтгэгч нь Засгийн газрын XIII байрны цонх солих засварын ажлыг гэрээний хавсралтад заасан төсөвт багтаан захиалагчийн тавьсан шаардлага болон гэрээнд заасан барилгын стандартын дагуу гүйцэтгэн, захиалагчид хүлээлгэн өгөх, захиалагч нь гэрээгээр тохиролцсон төлбөрийг гүйцэтгэгчид төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулна.


1.2 Энэхүү гэрээгээр зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоор зохицуулна.

1.3 Гэрээ нь талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулсанаар хүчин төгөлдөр болох бөгөөд талуудын гэрээгээр хүлээсэн үүрэг бүрэн биелсэнээр гэрээ дуусгавар болно.

Хоёр. Гэрээний зүйл

2.1 Гэрээт ажлыг 2022 оны ...-р сарын ...-ны өдрөөс эхлэн 2022 оны ...-р сарын ... -ны өдрийг дуустал хугацаанд бүрэн хийж гүйцэтгэн захиалагчид ажил хүлээлцэх актаар хүлээлгэн өгнө.

2.2 Захиалагчийн үйл ажиллагаа болон төлөвлөгдөөгүй хүндрэлээс хамаарч ажил саатсан хугацааг гэрээний хугацаанаас хасч тооцно.



Гурав. Гэрээний үнэ, төлбөр төлөх журам

3.1 Гэрээт ажлын нийт үнэ нь 19,874,510 /арван есөн сая найман зуун далан дөрвөн мянга таван зуун арван мянга/ төгрөг байх бөгөөд үүнд ажлыг гүйцэтгэхтэй холбоотой материал, тээвэр, ажлын хөлс, НӨАТ, татвар, бусад бүх зардал багтсан болно. Засварын ажил дуусч хүлээж авсан акт үйлдсэнээр төлбөрийг 100 хувь гүйцэтгэгчид олгоно.

3.2 Гэрээний нийт үнэ гэрээний явцад өөрчлөгдөхгүй, эцсийн дүн байна.

3.3 Ажлын төлбөрийг гүйцэтгэгчийн Худалдаа хөгжлийн банкны 499 230 423 тоот дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Захиалагчийн эрх, үүрэг

4.1 Захиалагч нь төлөөлөгч томилж гүйцэтгэгчийн барилгын ажлын явц, технологийг хянах, шаардлага тавих, зөрчил дутагдлыг гүйцэтгэгчид мэдэгдэн засуулах эрхтэй.

4.2 Захиалагч нь барилгын ажилд чанартай материал ашиглахыг гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

4.3 Барилгын ажлын гүйцэтгэлийн явцад болон гүйцэтгэсэн ажлын үр дүнг шалгах явцад доголдол илэрсэн бол өөрийн зардлаар засварлах, эсвэл ажлыг шинээр гүйцэтгэхийг гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

4.4 Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй, Захиалагчийн төлөөлөгчийн шаардлагыг биелүүлээгүй бол захиалагч гэрээнд заасан хариуцлага тооцох, гарсан хохирол зардлыг гүйцэтгэгчээр төлүүлэх, шаардлагатай тохиолдолд гэрээг цуцлах эрхтэй.


4.5 Гүйцэтгэгч тал гэрээт ажлыг заасан хугацаанд чанартай хийж гүйцэтгэсэн гэж үзэн актаар хүлээн авсаны дараа гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөрийг тогтоосон хугацаанд шилжүүлэх үүрэгтэй.

Тав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

5.1 Захиалагчаас гэрээний төлбөрийг гэрээнд заасан нөхцөлийн дагуу шилжүүлэхийг шаардах эрхтэй.

5.2 Захиалагчийг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.

5.3 Барилгын ажлын явцад захиалагч нь засварын ажилд нэмэлт өөрчлөлт оруулбал холбогдох зардал, хугацааг захиалагчтай урьдчилан тохиролцоно.



5.4 Гэрээт ажлыг батлагдсан зураг төсөл, Монгол Улсын барилгын стандарт, норм дүрэм болон захиалагчаас тавьсан шаардлагад нийцүүлэн, захиалагчийн төлөөлөгчийн хяналт дор гэрээнд заасан хугацаанд чанартай гүйцэтгэнэ.

5.5 Барилгын ажлын талбайг дүрэм журам, стандарт технологийн дагуу зөв зохион байгуулах, барилгын хог хаягдлыг тухай бүр цэвэрлэж хаях, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн ханган үйлдвэрийн осол гаргахаас урьдчилан сэргийлж ажиллах ба энэхүү үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг хариуцна.

5.6 Барилгын талбайд ажиллах ажиллагсдыг хөдөлмөрийн сахилга баттай, нарийн зохион байгуулалттай ажиллуулж, аливаа зөрчил дутагдал гаргуулахгүй байх арга хэмжээг авч ажиллана. Хэрэв ажиллагсад зөрчил дутагдал гаргасан тохиолдолд учирсан хохирлыг гүйцэтгэгч тал хариуцана.

5.7 Захиалагчийн тавьсан шаардлагыг бүрэн биелүүлж ажиллах үүрэгтэй.

5.8 Гүйцэтгэгч тал ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд 0,5%-ийн алданги төлнө.

5.9 Гүйцэтгэгч тал нь ажил гүйцэтгэх хугацаанд ажилчдынхаа ХАБЭА-г хангаж ажиллана.

Зургаа. Ажил дуусгавар болох, гэрээ цуцлах

6.1 Гүйцэтгэгч тал ажлыг заасан хугацаанд гүйцэтгэж захиалагч талд мэдэгдэх бөгөөд захиалагч талын томилогдсон төлөөлөгч ажил дууссан гэж үзвэл 7 хоногт багтаан ажил хүлээлцэх актаар хүлээн авна.

6.2 Энэхүү гэрээг аль нэг талын санаачлагаар цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, ажлын талбайг чөлөөлөх үүрэгтэй.

Долоо. Доголдлыг арилгах баталгаат хугацаа

7.1 Гүйцэтгэгч нь захиалагчид гэрээт ажлыг эцэслэн хүлээлгэн өгсөнөөс хойш ажлын чанарт 1 /нэг/ жилийн баталгаат хугацаа тогтооно. Энэ хугацаанд чанарын доголдол гарсан тохиолдолд захиалагч нь гүйцэтгэгчид мэдэгдсэнээс хойш ажлын 7 хоногийн дотор өөрийн хөрөнгөөр засч, учирсан хохирлыг барагдуулна.

Найм. Маргаан шийдвэрлэх

8.1 Энэхүү гэрээтэй холбогдон гарах аливаа маргааныг талууд үл маргах журмаар шийдвэрлэнэ.



8.2 Талууд үл маргах журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын Иргэний хуулийн дагуу Монгол Улсын Шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

Ес. Бусад

9.1 Гэрээг хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.

9.2 Талууд энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд бичгээр үйлдэж эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно. Ийнхүү хүчин төгөлдөр болсон нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

9.3 Гэрээний хувиуд нь хууль зүйн хувьд нэгэн адил хүчинтэй байна.

ТАЛУУДЫН ГАРЫН ҮСЭГ:

Захиалагчийг төлөөлж:

Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

 Ц.Одхүү

Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах шинжээч, ерөнхий нягтлан бодогч

 Г.Алтангэрэл

Хуулийн хэлтсийн мэргэжилтэн

 Б.Цэнд

Гүйцэтгэгчийг төлөөлж:

Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга


 Г.Долгорсүрэн

Барилгын инженер

 Ж.Наранбаяр

Нэгж хариуцсан мэргэжилтэн

 Я.Батболд



НЭХЭМЖЛЭХ №

Нэхэмжлэгч:

Байгууллагын нэр: ЗГБНҮГ азар
 НӨАТ төлөгчийн дугаар: 5340659
 Хаяг: Улаанбаатар, Чингэлтэй, 4-р хороо, Ж.Самбуугийн гудамж-11, 3Г-ын 11-р байр, 1 да
 Утас, Факс: 322011
 Электрон шуудан:
 Төлбөр хийх хугацаа: 2022/11/08
 Банкны нэр: ХУД ХӨГЖ ТӨВ БАНК

Төлөгч:

Байгууллагын нэр: Зам тээврийн хөгжлийн яам
 НӨАТ төлөгчийн дугаар:
 Хаяг:
 Гэрээний дугаар:
 Нэхэмжилсэн огноо: 2022/11/08
 Дансны дугаар: 499230423

№	Бараа, ажил үйлчилгээ	Тоо хэмжээ	Нэгж	Нэгж үнэ	НӨТ-гүй дүн
1	цонх засварын төлбөр	1	ш	18,067,736.36	18,067,736.36

Мөнгөний дүн (үсгээр) Арван есөн сая найман зуун далан дөрвөн мянга таван зуун арван болно.

Бүх дүн, НӨАТ-гүй: 18,067,736.36
НӨАТ (10%): 1,806,773.64
Нийт дүн: 19,874,510.00

(Тамга)

ЗАХИРАЛ
 ЕРӨНХИЙ НЯ-БО



/Ө.Лувсанренчин/
 /Г.Долгорсүрэн/

